

БАТЛАВ.  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГА

БАТЛАВ.  
"МОНФРУКТ" ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Э.ТАМИР

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 06-р сарын 01-ны өдөр

Дугаар

20 23 -03/165

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 –д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/535 тоот захирамжийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Цэдэнсүрэн, Ус ашиглагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, Cobfort plaza 11/02 тоот Утас: 77194949, 88098686, 99997478, Улсын бүртгэлийн 9011156027, регистрийн 2678586 дугаартай "Монфрукт" ХХК-ийн ерөнхий инженер Д.Мөнхзул нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр . Гэрээний нөхцөл:

- 2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:  
Барилгын чулуу үйлдвэрлэх
- 2.2. Ашиглах усны хэмжээ:  
-Ундарга нь 1 хоногт 86.4 м<sup>3</sup> ус авч ашиглах боломжтой. Хоногт дунджаар 30.0 м<sup>3</sup> ус ашигладаг.  
1 ажилтан хоногт 180 л ус хэрэглэнэ гэж үзвэл: 41 ажилтан 1 хоногт 7,38 м<sup>3</sup> 154 хоногт 1136,52м<sup>3</sup>  
Зам талбайн тоос дарах 1 удаагийн усалгаанд 30.0 м<sup>3</sup> ус хэрэглэнэ гэж 154 хоногт 4620,0 м<sup>3</sup>  
**Нийт 5736.52м<sup>3</sup>**
- 2.3. Усны чанар, найрлага:  
Шинжилсэн хими болон нянгийн үзүүлэлтүүд нь "Унд ахуйн усны эрүүл ахуйн стандарт MNS:0900:2018"-ын шаардлага хангаж байна.
- 2.4. Усны эх үүсвэрийн:  
Байршил: Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Баруун турууны аманд  
Солбицол: 47°56'39.73"N, 106°38'19.51"E  
Барилга байгууламж: Үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан гаргасан 100 м гүнтэй 1 худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.  
Тоног төхөөрөмж нэр марк: Худагт QJP 2.2 квт 3 тн-ын 220 вт усны насосыг 90 м гүнд суурилуулсан.
- 2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга түвшин:  
Бетонон доторлогоотой бохирын цооногтой.0
- 2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ /кг/:  
Улиралд 1704,78м<sup>3</sup>/жил
- 2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: -





2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: -

2.9. Усны тоолуурын:

Загвар, нэр, дугаар: LXSG-20 загварын 4.0 м<sup>3</sup>/ц хэмжих хязгаартай, 20 мм -ийн голчтой №202000088-ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 022 лацаар битүүмжилж, 2022 оны 08 –р сарын 27 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгосон.

Тоолуурын тоо: 1

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2022 оны 08 дугаар сарын 27-ны өдөр

Тоолуурын заалт: Тоолуурын заалт 2023 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 000106 м<sup>3</sup>.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2020-2021 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай”, Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 302, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор тоолуурын заалтаар /1м<sup>3</sup> усны төлбөр 99.12/ төлбөр төлнө.

#### Гурав. Талуудын эрх үүрэг.

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

#### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.


4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Усан орчин ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын  
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн  
Ахлах мэргэжилтэн  Д.Цэдэнсүрэн


Байгаль орчин, ногоон байгууламж  
хариуцсан мэргэжилтэн

 С.Сүхцоож

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн  
27 дугаар хороо

Харилцах утас: 70173213

Ус ашиглагчийг төлөөлж:

“Монфрукт” ХХК-ийн  
ерөнхий инженер  
 Д.Мөнхзул

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн  
33 дугаар хороо

Харилцах утас: 99095658

